



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2009 оны 7 сарын 24 өдөр

Дугаар 338

Улаанбаатар хот

**ДҮРЭМ, ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 1994 оны 171, 2000 оны 185 дугаар тогтоолын 6 дугаар заалтыг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ**:

1. "Нийслэлийн Нийгмийн даатгалын газрын дүрэм"-ийг нэгдүгээр "Нийслэлийн Нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө"-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Нийгмийн даатгалын хууль тогтоомж, Засгийн газрын болон Нийспээлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн толовлөгөөг хэрэгжүүлэхэд ажлаа чиглүүлж, тодорхой үр дүнд хүргэхийг Нийслэлийн Нийгмийн даатгалын газар /Д.Гонгор/-т үүрэг болгосугай.
3. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1997 оны Б/48 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

0201117

Нийслэлийн Засаг даргын 2002 оны 338-р  
захирамжийн хавсралт

## НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн нийгмийн даатгалын газар нь /цаашид “газар” гэх/ нийслэлийн нутаг дэвсгэрт нийгмийн даатгалын үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, биелэлтэнд хяналт тавих төрийн захиргааны орон нутгийн байгууллага мен.

1.2 Газар нь үйл ажиллагаандaa Монгол Улсын Үндсэн Хууль болон Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжууд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3 Газар нь нийслэлийн нутаг дэвсгэрт нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, биелэлтэнд хяналт тавих, иргэд ажил олгогчдыг даатгалд хамруулах, шимтгэлийн орлогыг хуримтлуулах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох, нийгмийн даатгалын байгууллагын зохион байгуулалт тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох, судалгаа шинжилгээ хийх, санал боловсруулж шийдвэрлүүлэх, сургалт сурталчилгаа явуулах, хот, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, ажилтаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үйл ажиллагааг эрхлэнэ.

1.4 Газар нь Нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар болон Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдлагын дор ажиллаж тэдгээрт ажлаа тайлагнана.

1.5 Газар үйл ажиллагаандaa хууль дээдлэх, даатгуулагч, ажил олгогчийн хууль ёсны эрх ашиг, сонирхолыг хүндэтгэх, бусдын нэлөөнд үл автах зарчим баримтална.

1.6 Газрын даргыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцэж Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга томилж, чөлөөлнө.

1.7 Газрын дарга нь эрхлэх ажлын хүрээний эрх хэмжээний асуудлаар тушаал гаргана.

1.8 Газрын дарга нь ажилтнуудыг ажилд томилж чөлөөлнэ.

1.9 Газар нь биеэ даасан үйл ажиллагаа явуулж тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, өөрийн төсөвтэй, банкинд харилцах данстай байна.

1.10 Газрын үйл ажиллагааны зардлыг нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоос санхүүжүүлнэ.

1.11 Газрын даргад зөвлөх эрхтэй Байгууллагын зорилт, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх зөвлөлийг байгуулан ажиллуулж болно.

1.12 Газрын дэргэд ажил олгогч, даатгуулагч болон нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөвүүг хянан шийдвэрлэх гомдлын шаардлагын орон тооны бус зөвлөл ажиллана. Тус зөвлөлийн дарга нь газрын дарга байна.

## Хоёр. Газрын үүрэг

2.1 Газар нь Монгол улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх

2.2 Холбогдох хууль, тогтоомж, Нийслэлийн Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн үр дүнг хугацаанд нь тайлгнах

2.3 Нийслэлийн нутаг дэвсгэрт Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, түүний хэрэгжилтэнд хяналт тавьж даатгуулагч болон цэргийн албан хаагчдад тэтгэвэр тэтгэмж тогтоон олгох, үйлчилгээний төлбөр олгох ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх,

2.4 Нийслэлийн нутаг дэвсгэрт ажил олгогч, даатгуулагчаас нийгмийн даатгалын шимтгэлийг зохих хугацаанд нь даатгалын сан тус бүрт хуримтлуулахын зэрэгцээ улсын төсвээс олгох татаасыг авч даатгалын сангудын орлогыг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх

2.5 Нийслэлийн нутаг дэвсгэрт ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ олгох, бүртгэл хетлех ажлыг зохион байгуулж хэрэгжилтэнд нь хяналт тавих

- 2.6 Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс /тасаг/-г удирдан даатгалын сангудын орлого зарлагын төсвийг батлах, өөрчлөлт оруулах, үйл ажиллагаанд нь үнэлэлт өгөх, хяналт тавих, шалган зааварлах, тэргүүний арга барилыг сурталчлах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авах.
- 2.7 Нийслэлийн нийгмийн даатгалын сангудын хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу нийцүүлэн захиран зарцуулах, тайлан мэдээ, мэдээллийг тогтоосон журмын дагуу гаргаж байх .
- 2.8 Нийслэлийн хэмжээнд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтрах буюу дангаараа нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, таниулах, иргэдийг нийгмийн даатгалын талаар зохих мэдлэгтэй болгох арга хэмжээ авах.
- 2.9 Нийгмийн даатгалын сангудын жилийн орлого, зарлагын тесөв, эрүүл мэндийн даатгалыг төр хариуцах иргэдийн хураамжид улсын төсвееөс олгох хөрөнгө болон нийгмийн даатгалын байгууллагын төсвийн төслийг жил бүр зохиож Улсын нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх.
- 2.10 Нийслэлийн нутаг дэвсгэрт нийгмийн даатгалын ажлыг мэдээллийн сүлжээнд оруулан нэгдсэн данс бүртгэлтэй болгох ажлыг зохион байгуулах.
- 2.11 Нийгмийн даатгалын байгууллагыг үнэнч шудрага, нийгмийн даатгал, санхүү бүртгэл, анагаах ухааны ажлын зохих мэдлэгтэй, дадлага туршлагатай, чадварлаг боловсон хүчинээр бэхжүүлэх .
- 2.12 Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, нөхцөл, хэмжээ, хугацааны мэдээлэл, тодорхойлолтыг хянаж, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын ажлыг шалган зааварлах.
- 2.13 Эрхэлж буй ажлын хүрээнд холбогдох шаардлагатай асуудлаар санал боловсруулан Засаг даргад оруулж, шийдвэрлүүлэх.
- 2.14 Ажил олгогч, даатгуулагчийн өргөдөл, гомдол, мэдээллийг хянаж шийдвэрлэх.
- 2.15 Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст хүргүүлж, хянуулах.
- 2.16 Байгууллагын хэмжээнд сахилга дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтанд хяналт тавих.
- 2.17 Дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /тасаг/-ийн чадавхийг дээшлүүлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах.
- 2.18 Газар нь Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, шимтэлийн орлогыг бүрдүүлэх, нийгмийн даатгалын зарлага санхүүжилтийн талаар нийслэлийн санхүү, татвар, статистикийн алба, банктай ажлаа нягт

уялдуулан мэдээллээр хангах, солилцох, тайлан мэдээг тогтоосон хугацаанд нь гаргаж өгөх зэргээр хамтран ажиллана.

### **Гурав. Газрын эрх**

3.1 Нийслэлийн нутаг дэвсгэрт даатгуулагчдын эрх ашгийг хамгаалж анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй, хөдөлмөрийн хөлсний орлогыг тодорхойлох боломжгүй болсон ажил олгогчид түүнтэй адилтгах үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа ажил олгогчийн төлөх шимтгэлтэй адиллаар шимтгэл ногдуулах

3.2 Тогтоосон хугацаанд шимтгэл төлөөгүй ажил олгогчийн банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг хууль тогтоомжид заасны дагуу түр зогсоох

3.3 Нийгмийн даатгалын байцаагчаас тавьсан актад заасан шимтгэл алданги, хүү торгуулийг хугацаанд нь төлөөгүй бол уг шимтгэл, алданги, хүү торгуультай тэнцэх хэмжээний хөрөнгийг зохих хууль тогтоомжийн дагуу гаргуулах

3.4 Илүү төлсөн шимтгэлийг дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд суутган тооцох буюу шимтгэл төлөгч хүсвэл тооцоо хийснээс хойш 30 хоногийн дотор эргүүлж олгох

3.5 Шимтгэл, алданги, хүү торгууль төлөхөөс зайлсхийсэн, шимтгэлийн мэдээ тайланг хугацаанд нь ирүүлээгүй, нийгмийн даатгалын байгууллагын хяналт шалгалтаар илэрсэн зерчлийг арилгах арга хэмжээ аваагүй ажил олгогчид хуульд заасан хариуцлага хүлээлгэх

3.6 Дүүргүүдийн нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг төвлөрүүлэн авч нэгдсэн журмаар хуваарилан зарцуулах

3.7 Нийгмийн даатгалын хяналт хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, бусад холбогдох баримт бичгийг ажил олгоч болон даатгуулагчаас үнэ төлбөргүй гаргуулан авах

3.8 Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны ажилдаа тэнцэж байгаа эсэхэд дүгнэлт өгөхийн тадна тэднийг ажлын үр дүнг нь харгалзан хууль тогтоомжид заасны дагуу шагнаж урамшуулах, цалинг нэмэгдүүлэх, бууруулах, төр засгийн шагнаалд уламжлах.

3.9 Гадаад орны ижил төрлийн байгууллагатай нийгмийн даатгалын асуудлаар ажил хэргийн холбоо тогтоож хамтран ажиллах

3.10 Дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс гаргасан шийдвэр болон байцаагчийн тавьсан актыг үндэслэлгүй гэж үзвэл хүчингүй болгох буюу өөрчлөх

3.11 Дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн даргыг тухайн дүүргийн Засаг даргатай зөвшилцэж томилж, чөлөөлөх

3.12 Дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэс / тасаг/-ийн болон дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын ажлыг үнэлж дүгнэн шигнан урамшуулах ба зэмлэл хүлээлгэх

3.13 Нийгмийн даатгалын байцаагчдаас тавьсан акт, шийдвэрийг батламжлах

3.14 Газар нь дараах асуудлаар хуулийн байгууллагад нэхэмжлэл буюу томдол гаргана.

а) Шимтгэл, торгууль, алдангийг бүрэн буюу хагас хэмжээгээр төлөөгүй, нийгмийн даатгалын хууль тогтоомж ноцтой зөрчсөн, ажил олгогчийн хөрөнгөөс төлбөр гаргуулахаар

б) Албан үүргээ гүйцэтгэхэд нь нийгмийн даатгалын байгууллагын ажилтанд саад учруулсан, эсэргүүцэл үзүүлсэн, түүнийг үйл ажиллагаатай нь холбогдуулан мөрдөн хавчсан, амь бие, эрүүл мэндэд нь хохирол учруулсан гэм буруутай этгээдэд зохих хууль тогтоомжийн дагуу шийтгэл хүлээлгэхээр

в) Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг төвлөрүүлэхгүй саатуулах, санг зүй бусаар зарцуулсан байгууллага, хувь хүмүүсийн асуудлаар

3.15 Шаардлагатай тохиолдолд нийгмийн даатгалын чиглэлээр нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний үндэслэл, баталгаа, нөхцлийг хянаж шийдвэрлэх

3.16 Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны төсвийг батлах төсвийн төслийг нэгтгэн боловсруулах, төсвийг захиран зарцуулж тайлгнах

3.17 Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжинд заасан бусад эрх.

## Нийслэлийн нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1.1 Оршил

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө /цаашид төлөвлөгөө гэнэ/-нд Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газрын болон Нийслэлийн Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн стратегийн төлөвлөлт, захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэнд хяналт тавих, судалгаа шинжилгээ хийх, дүгнэлт, үнэлгээ өгөх, нийгмийн даатгалын сангийн бүрдүүлэлт зарцуулалт, нийгмийн даатгалын хамралт, үйлчилгээний асуудлыг хамарсан үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

#### 1.2 Үндэслэл

Төлөвлөгөөг Монгол улсын Засгийн газрын удирдлагын хөгжлийн хөтөлбөр /1996 он/, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /2002 он/, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр /2001 он/, "Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын бүтэц, орон тооны норматив батлах тухай" Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2001 оны 75-р тушаал зэрэг бусад хууль эрхийн баримт бичгийг үндэслэн боловсруулав.

#### 1.3 Хууль тогтоомжийн тухай

Төлөвлөгөөг дор дурьдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

- Монгол усны Үндсэн хууль
- Монгол улсын Засгийн газрын тухай хууль
- Монгол улсын Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль
- Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль
- Монгол улсын Нийгмийн даатгалын тухай хууль
- Монгол улсын Төрийн албаны тухай хууль
- Улсын Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал
- Нийслэлийн Иргэдийн Төлөвлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн засаг даргын захирамж
- Бусад хууль, тогтоомж

#### **1.4 Нийслэлийн нийгмийн даатгалын газрын үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь**

Нийслэлийн нийгмийн даатгалын газар нь нийслэлийн нутаг дэвсгэрт нийгмийн даатгалын үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж, Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газар болон нийслэлийн Засаг даргаас нийгмийн даатгалын талаар дэвшүүлсэн зорилт, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавьж дүгнэлт, үнэлгээ өгөх, хамрах хүрээний асуудлыг уялдуулан зохицуулах /тохируулах/ уурэг хариуцлага хулээнэ.

## **1.5 Стратегийн удирдлага, зохион байгуулалтын хэрэгцээний эхүүсээр**

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчилэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус газрын үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурьдсан үйлчилүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана.



Нийслэлийн нийгмийн даатгалын газрын үндсэн хэрэглэгч буюу үйлчлүүлэгч нь Улсын Нийгмийн даатгалын Ерөнхий газар болон Нийслэлийн Засаг дарга, ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчид байна. Нийслэлийн нийгмийн даатгалын газрын стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурьдсан хэрэглээний эх үүсвэр, ялангуяа үндсэн хэрэглэгч буюу үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогdon үүсэх харилцааг зохицуулахад чиглэнэ.

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах, үйлчилгээний хүрээ, төрөл хэлбэрийн хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын байр, /албан тушаал/-ны тодорхойлолтонд нарийвчлан тусган хэрэгжүүлнэ.

### **Хоёр. Нийслэлийн нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны стратеги**

#### **2.1 Үйл ажиллагааны стратегийн мөн чанар**

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь тус газрын эрхэм зорилго, зорилтыг тодорхойлж Нийслэлийн нутаг дэвсгэрт нийгмийн даатгалын төрийн бодлогыг хэрэгжүүлэх, даатгуулагчдын нийгмийн баталгааг хангах, эрх ашгийг дээдлэн хүндэтгэж хамгаалах, нийгмийн даатгалын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй шуурхай явуулах, Улсын нийгмийн даатгалын өрөнхий газар болон Нийслэлийн засаг даргын үйл ажиллагаанд мэргэжлийн үйлчилгээг шуурхай үзүүлэхэд оршино.

#### **2.2 Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл**

Нийслэлийн нийгмийн даатгалын газар нь дор дурьдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй байна.

- Монгол улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангах, эрх ашгийг хамгаалах
- Нийгмийн даатгалд хамрах хүрээг өргөтгөж, ажил олгогч, даатгуулагчдыг бүрэн хамруулах арга хэмжээ авах
- Нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, эх үүсвэрийг нэмэгдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах
- Тэтгэвэр тэтгэмж, эмчилгээ, үйлчилгээний зардлыг тогтоосон хугацаанд нь саадгүй олгох
- Монгол улсын Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, шалгах, мэргэжлийн зөвлөлгөө өгөх, сурталчлах, судалгаа шинжилгээ, үнэлгээ, дүнгэлт хийх
- Нийгмийн даатгалын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй шуурхай явуулах, иргэн бүр даатгуулагч байх нөхцөл, бололцоог хангах
- Нийслэлийн нутаг дэвсгэрт нийгмийн даатгалын байгууллагын оновчтой бүтэц бүхий тогтолцоо бүрдүүлэх, үйл ажиллагааны чанарын түвшинг дээшлүүлэх

### **2.3 Үйл ажиллагааны эрхэм зорилго**

#### **Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын эрхэм зорилго**

Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын оновчтой, зөв бүтэц бүхий тогтолцоог зах зээлийн эдийн засгийн харилцаанд нийцуулэн, даатгалын үйл ажиллагааг чанартай, хүртээмжтэй явуулах, даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах эрх ашгийг хамгаалах, иргэн бүр даатгуулагч байх нөхцөл, бололцоог бүдүүлэх, нийгмийн даатгалын хууль, тогтоомжийг нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх, даатгуулагч иргэдийг найдвартай, шуурхай үйлчилгээгээр үйлчилж, тэдний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрхийг баталгаатай хангах явдал мөн.

### **2.4 Үйл ажиллагааны стратегийн зорилт**

Нийслэлийн нийгмийн даатгалын газар нь эрхэм зорилгынхoo хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурьдсан зорилтыг хэрэгжүүлнэ.

- 2.4.1 Монгол улсын нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгоч, даатгуулагч болон нийгмийн даатгалын байгууллагуудад шалгах, нийгмийн даатгалд хамрах хүрээг өргөтгөх, нийгмийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тэтгэвэр, тэтгэмж тогтоолт, олголт, эмчилгээ үйлчилгээний зардлын санхүүжилтэнд хяналт тавих, судалгаа шинжилгээ, үнэлгээ дүгнэлт хийх.
- 2.4.2 Монгол улсын Ирэгний эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтийг дааттуулагчид улсын болон хувийн эмнэлгийн байгууллагуудад шалгах, эрүүл мэндийн даатгалд хамрах хүрээг өргөтгөх эмчилгээ үйлчилгээний зардлын тооцоо хийж санхүүжилт олгох, гүйцэтгэлд хяналт тавих
- 2.4.3 Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудад нягтлан бодох бүртгэл, мэдээ тайлангийн ажлыг Монгол улсын нягтдлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомжийн дагуу явуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, цахим тооцоололт, мэдээллийн сүлжээг зохицуулах, техник хэрэгслэлээр хангах, нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны төсвийг төлөвлөх, гүйцэтгэлийг зохион байгуулах, хяналт тавих, судалгаа шинжилгээ, үнэлгээ дүгнэлт хийх, шалгаж зааварлах, мэргэжлийн удирдлагаар хангах
- 2.4.4 Захиргааны удирдлагын манлайлалыг хангах, удирдлагын чадавх үр өгөөжийг дээшлүүлэх

### **2.5 Үйл ажиллагааны гол зорилт**

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дор дурьдсан зорилтыг дэвшүүлэн ажиллана.

Үйл ажиллагааны стратегийн нэгдүгээр зорилтын хурээнд:

1.1 Монгол улсын Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагчид болон нийгмийн даатгалын байгууллагуудад шалгах мэргэжлийн зөвлөлгөө өгөх, зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх

1.2 Нийгмийн даатгалын сангудын орлого, зарлагын төлөвлөлт, биелэлт, зарцуулалтанд хяналт тавих, судалгаа шинжилгээ хийж, үнэлгээ дүгнэлт гаргах

1.3 нийспэлийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын нийгмийн даатгалын шимтгэлийн оногдуулалт, төлөлт, тайллагналтын байдалд шалгалах

1.4 Дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /тасаг/-ийн ажлыг дүгнэж, үнэлгээ өгөх

1.5 Тэтгэвэр, тэтгэмж тогтоолт, олголт, эмчилгээ үйлчилгээний зардлын санхүүжилтийг шалгах

1.6 Ажил олгогч, даатгуулагчдын нийгмийн даатгалд хамрах хүрээг өргөтгөх

Үйл ажиллагааны хоёрдугаар зорилтын хурээнд:

2.1 Монгол улсын иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт, эмчилгээ үйлчилгээний чанарт хяналт тавих, шалгах, бодлого зохицуулах, мэргэжлийн зөвлөлгөө өгөх, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх

2.2 Иргэний эрүүл мэндийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг шалгах, судалгаа шинжилгээ, дүгнэлт хийх

2.3 Эрүүл мэндийн даатгалд хамрах хүрээг өргөтгөх, сайн дурын даатгалд даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх

2.4 Иргэний эрүүл мэндийн даатгалын сангаас эмчилгээ үйлчилгээний зардалд олгосон хөрөнгийн тайлан, тооцоог хянаж, санхүүжилтийг тогтоосон хугацаанд олгох

2.5 Улсын болон хувийн хэвшлийн эмнэлэг, эмийн сан, амбулатори, өрхийн эмэнлэгтэй гэрээ байгуулж, биелэлтийг дүгнэх, эмчилгээ, үйлчилгээний зардлын гүйцэтгэлд хяналт тавих, шалгах

2.6 Иргэний эрүүл мэндийн даатгалд даатгуулагчдын мэдээллийн сан бүрдүүлэх, программ хангамжийг боловсронгуй болгох, нэгдсэн сүлжээг ашиглан дотоодын хяналтыг сайжруулах

2.7 Улсын болон хувийн хэвшлуудийн эмнэлгийн орны тоо, эмчилгээний зардлын норматив, санхүүжилтийн төсвийн тооцоог хийж, батлуулж, мөрдөх

Үйл ажиллагааны гуравдугаар зорилтын хүрээнд:

3.1 Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтэнд хяналт тавих, мэргэжлийн зөвлөлгөө өгөх, зерчил дутагдаас урьдчилан сэргийлэх

3.2 Нийслэлийн нийгмийн даатгалын сангудын орлого, зарлагын төлөвлөгөө, үйл ажиллагааны төсвийг батлуулж хуваарилах, гүйцэтгэлийг хангах, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавих

3.3 Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын бүртгэл, тооцоо, тайлан тэнцэлд олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг нэвтрүүлэх

3.4 Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийн сан бүрдүүлэх, нэгдсэн сүлжээг нэвтрүүлэх, программ хангамжийг сайжруулах, цахим техник хэрэгслэлээр хангах

3.5 Тэтгэвэр тэтгэмж, эмчилгээ үйлчилгээний зардал, үйл ажиллагааны төсвийн санхүүжилтийг хугацаанд нь олгох

Үйл ажиллагааны дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

4.1 Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага, захиргааны удирдлагын манлайлалыг хангах, оновчтой бүтэц бүхий тогтолцоо бүрдүүлэх, удирдлагын стратеги, төлөвлөгөөтэй ажиллуулах

4.2 Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудыг санхүү, эдийн засаг, анагаах ухааны боловсролтой, нийгмийн даатгалын мэргэшсэн, үнэнч, шудрага, чадвартай боловсон хүчинээр бэхжүүлэх

4.3 Нийслэлийн нийгмийн даатгалын анхан шатны байгууллагуудыг хүний нөөц, захиргааны удирдлагаар хангах

4.4 Удирдах дээд байгууллагуудын шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих

4.5 Терийн албаны бичиг хэргийн хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх

**2.6 Үйл ажиллагааны зорилт:**

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны зорилт бол Монгол улсын Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тодорхойлж хэрэгжүүлнэ.

**2.7 Үйл ажиллагааны стратегийн загвар**

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг дор дурьдсанаар тодорхойлж байна

## Нийслэлийн нийгмийн даатгалын газрын үйл ажиллагаа/бизнес/-ын стратегийн загвар

Эрхэм зорилго	Үйл ажиллагааны стратегийн зорилт	Үйл ажиллагааны гол зорилго
<b>Нийслэлийн нийгмийн даатгалын байгуулгын оновчтой бугац бухий тогтолцсог зах зээлийн эдийн засгийн харилцааны дагуу бүрдүүлэх, цаатгалын үйл ажиллагаа г чанартай хуртэмжтэй явуулах, даатгуулагчны нийгмийн баталгааг хангах, арх ашиг хамгаалах, иргэн бүр дааттуулагч байх нехцел бололцоог хангах явдал ман.</b>	<p><b>2.4.1 Монгол улсын нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ажил слгсгч, даатгуулагч болон нийгмийн даатгалын байгууллагуудад шалгах, нийгмийн даатгалд хамрах хүрээг өргөтгэх, нийгмийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тэтгэвэр тэтгэмж тогтоолт, олготг, эмчилгээ үйлчилгээний зардлын санхүүжилтэнд хяналт тавих, судалгаа шинжилгээ, үнэлгээ дүгнэлт өгөх</b></p> <p><b>2.4.2 Монгол улсын Иргэний оруул мэдэгийн даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжүүлэх биелэлтийг даатгуулагчид, улсын болон хувийн хэвшлийн симплгийн байгууллагуудад шалгах эрүүл мэндийн даатгалд хамрах хүрээг оротгох, эмчилгээ үйлчилгээний зардлын тооцоо хийж санхүүжилт олгох, гүйцэтгэлд хяналт тавих</b></p> <p><b>2.4.3 Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудад нягтлан бодох бүртгэл мэдээ тайлангийн ажлыг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомжийн дагуу явуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, цахим тооцоолот, мэдээллийн сүлжээг зохицуулах, техник хэрэглэлээр хангах, нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны төсвийг төвлөвлөх, гүйцэтгэлийг зохион байгуулах, хяналт тавих, судалгаа шинжилгээ хийж үнэлгээ дүгнэлт хийх, шалгах зааварчлах, мэргэжлийн удирдлалагаар хангах</b></p> <p><b>2.4.4 Захиргааны удирдлалын мэнлайбалыг хангах, удирдлалын чадавхийг сайжруулж, үр огоожийг дээшлүүлж</b></p>	<p>Монгол улсын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагчид болон нийгмийн даатгалын байгууллагуудад шалгах, мэргэжлийн зөвлөлгөө өгөх, зорчил дутагдаж гарахаас урьдчилсан сэргийлэх</p> <p>Нийгмийн даатгалын сангудын орлого, зарлагын талваалалт, биелэлт, зарцуулалтанд хяналт тавих, судалгаа шинжилгээ хийж, үнэлгээ дүнэлт гарах</p> <p>Нийслэлийн нутаг давсгарт үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нариг, байгууллагуудын нийгмийн даатгалын шимтэглийн оногдуулалт, төлөлт, тайлангын байдалд шалгалах хийх</p> <p>Дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /тасаг/-ийн ажлыг дүгнаж, үнэлгээ огех</p> <p>Тэтгэвэр, тэтгэмж тогтоолт, олготг, эмчилгээ үйлчилгээний зардлын санхүүжилт, гүйцэтгэлийг шалгах</p> <p>Ажил олгогч, даатгуулагчдын нийгмийн даатгалд хамрах хүрааг өргөтгэх</p> <p>Монгол улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт, амчилгээ үйлчилгээний чанарт хяналт тавих, шалгах, бодлого ахицуулах, мэргэжлийн зөвлөлгөө өгөх, зорчил дутагдлаас урьдчилсан сэргийлэх</p> <p>Иргэний ЭМД-ын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг шалгах, судалгаа шинжилгээ, үнэлгээ дүнэлт хийх</p> <p>Ириэнд хамрах хүрээг өргөтгэх, сайн дурын даатгагд даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх</p> <p>Эрүүл мэндийн даатгалын сангас эмчилгээ, үйлчилгээний зардалд олгогон хөрөнгийн тайлан тосцоог хянаж, санхүүжилтийг тогтоосон хуяацаанд олгох</p> <p>Улсын болон хувийн хэвшлийн эмнэлэг, эмийн сан, амблотори, ерхийн эмнэлэгтэй гарэе байгуулж, биелэлтийг дүнэх, амчилгээ үйлчилгээний зардлын гүйцэтгэлд хяналт тавих, шалгах</p> <p>Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчдын мэдээллийн сан бүрдүүлэх, программын хангамжийг боловсронгуй болгох, наадсан сүлжээг ашиглан дистод хяналтыг сайжруулах</p> <p>Улсын болон хувийн хэвшлийн эмнэлгийн орны тоо, эмчилгээний зардлын норматив, санхүүжилтийн төсвийн тооцоог хийж батлуулж мөрдөх</p> <p>Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжүүлэх, биелэлтэнд хяналт тавих, мэргэжлийн зөвлөлгөө өгөх, зорчил дутагдлаас урьдчилсан сэргийлэх</p> <p>Нийслэлийн чийтийн даатгалын сангудын орлого, зарлагын толоволгоо, үйл ажиллагааны төсвийг батгуулж, хуваарилак, гүйцэтгэлийг хангах, анхан шатны болон нягтан бодох бүртгэлийн хэтрэлт тайлан тооцал гаргах ажлыг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагавар хангах, гүйцэтгэлд хяналт тавих</p> <p>Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын бүртгэл, тооцо, тайлан танцэлд олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт нэвтрүүлах</p> <p>Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийн сан бүрдүүлэх, наадсан сүлжээг нэвтрүүлах, программын хангамжийг сайжруулах цахим техник хэрэгслэлээр хангах</p> <p>Тэтгэвэр тэтгэмж эмчилгээ үйлчилгээний зардал, үйл ажиллагааны төсвийн санхүүжилтийг хугацаанд нь олгох</p> <p>Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын захиргээны удирдлагын манлайбалыг хангах, оновчтой зөв бутэц бүхий тогтолцоо бүрдүүлэх удирдлалын стратеги толевлэгээтэй ажиллуулах</p> <p>Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудыг хууль ээх зүй, санхүү, менежментийн боловсролтой нийгмийн даатгалын салбарт мэргэшсэн, үнэнч шүдрага Чадвартай болоасон хүчинээр бэхжүүлэх</p> <p>Нийслэлийн нийгмийн даатгалын анхан шатны байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлалагаар хангах</p>

**3 Нийслэлийн нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, шинэчлэлийн талаарх баримтлал**


**3.1 Бүтцийн ерөнхий тогтолцоонд баримтлах зарчим нь:**

Хараат бус биеэ даасан байх, эрх мэдлийн ялгаа нь тодорхой, итгэл хүлээхүйц байх, үзэгдэхүйц үйлчилгээний ба стратегийн удирдлагын баримжаатай байх, бүтцийн хувьд энгийн, тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох, улс төрийн хувьд төвийг сахисан, хангалттай чадавхи, бодитой байх

**3.2 Нийслэлийн нийгмийн даатгалын газар нь нийслэлийн нутаг дэвсргэрт нийгмийн даатгалын талаар дэвшүүлсэн зорилт, бодлогыг хэрэгжүүлэхэд тус газрын шинэчлэлийн агуулга байх болно**

**3.3 Дээр дурьдсан зарчим, шинэчлэлийн талаарх баримтлал, улсын нийгмийн даатгалын ерөнхий газар болон Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын стратегийн загварыг үндэслэн Нийслэлийн нийгмийн даатгалын газрын бүтцийн ерөнхий тогтолцоог дор дурьдсан загвараар тогтоож байна.**

**Нийслэлийн нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар**




**3.4 Нийслэлийн нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны стратегийн болон ерөнхий тогтолцооны зарчмаас үндэслэн зохион байгуулалтын бүтцийн дараах нэгжүүд ажлын байр зохион байгуулагдана**

### НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛАГЫН БҮТЭЦ

#### НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР /Орон тоо -25/




### НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН БҮТЭЦ



### ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН БҮТЭЦ

#### НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА



### **Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн үндсэн үүрэг, чиглэл нь:**

Монгол улсын Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч болон нийгмийн даатгалын байгууллагуудад шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, мэргэжлийн зөвлөлгөө өгөх дүгнэлт, үнэлгээ гаргах, судалгаа шинжилгээ хийх, зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх, нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх, үйлчилгээг хөнгөн шуурхай явуулах, даатгуулагчдын нийгмийн баталгааг хангах, эрх ашгийг хамгаалах.

### **Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн үндсэн үүрэг, чиглэл**

Монгол улсын иргэний эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж, хэрэгжилтийг эмнэлгийн байгууллага, даатгуулагчдад шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, мэргжлийн зөвлөлгөө өгөх, эмчилгээ үйлчилгээний зардлын тооцоо хийж, санхүүжилт олгох, эрүүл мэндийн даатгалын ажлын чиглэлээр асуудал боловсруулах, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах

### **Санхүү бүртгэл, тооцоололтын хэлтсийн үндсэн үүрэг, чиглэл нь:**

Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагудын нягтлан бодох бүртгэл, мэдээ тайлангийн ажлыг хууль, тогтоомжийн дагуу явуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, цахим тооцоололт, мэдээллийн сүлжээг зохицуулах, техник хэрэгслэлээр хангах, нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны төсвийг төлөвлөх, хуваарилах, гүйцэтгэлийг хангахад чиглэсэн судалгаа, шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт гаргах, дүүргүүдийг шалгаж, зааварлах, мэргэжлийн удирдлагаар хангах.

### **Үйлчилгээний албаны үндсэн үүрэг чиглэл нь:**

Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын бие даасан байдал, нийгмийн баталгааг хангах, мэргэжилтэн чадварлаг боловсон хүчинээр бэхжүүлэх, сургалт явуулах хэлтэс, тасаг, ажилтнуудын ажлыг үнэлж дүгнэх, газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг нэгтгэн гаргаж, дүгнэлт хийж ажиллах, ажил олгогч даатгуулагч, иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэх, Монгол улсын хуулиуд, УИХ, Засгийн газрын болон яам, дээд шатны байгууллагын тогтоол, шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах

## **НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР**